



УЛААНБААТАР  
ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/ОЧ.

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 14 дүгээр тогтоолын тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Улаанбаатар зам засвар, арчлалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 2.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төсвийн сахилга, хариуцлагыг чангатгаж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулах зорилгоор төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулан, явц, үр дүнг тухай бүр даргын зөвлөлийн хуралд танилцуулан ажиллахыг Үйл ажиллагаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Д.Ариунболд/-д даалгасугай.

3. Төлөвлөгөөний биелэлтийн тайланг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтэст улирал бүрийн сүүлийн сарын 20-ний өдрийн дотор хүргүүлж байхыг Тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн /Ж.Мөнхжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ЧИНЗОРИГ

"Улаанбаатар зам засвар, арчлалтын газар"  
ОНӨААТҮГ-ын даргын 2018 оны 2 дугаар сарын  
29-ний өдрийн 29 дугаар тушаалын хавсралт

"УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ-ААС 2018 ОНД  
ТӨСВИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ТУХАЙ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зохиох ажлын чиглэл	Хугацаа	Хариуцах хэлтэс, нэгж	Хамтран оролцох нэгж
1	Улсын Их Хурлаас 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон 2018 оноос хэрэгжиж эхлэх татварын хуулиудын хэрэгжилтийг зохион байгуулан, ажилчдад уг хуулийн нэмэлт өөрчлөлтүүд болон хэрэгжиж эхлэж байгаа хуулийг таниулан сурталчлах	2 дугаар сард	Захиргаа, санхүүгийн хэлтэс	Нийт хэлтэс албадууд
2	Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, аливаа өр, авлага үүсгэхгүй байх үүссэн өр, авлагыг төлөвлөгөө боловсруулан барагдуулах	Тогтмол	Захиргаа, санхүүгийн хэлтэс	Нийт хэлтэс албадууд
3	Арилжааны банк дахь бүх байгууллагын цалингийн болон жижиг мөнгөн сангийн данснаас бусад дансыг хааж, төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлэх	3 дугаар сард	Захиргаа, санхүүгийн хэлтэс	-
4	Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх төлбөртэй авто зогсоолын орлогыг хуваарийн дагуу биелэлтэд анхаарч ажиллах	Тогтмол	Үйл ажиллагаа, төлөвлөлтийн хэлтэс	-
5	Нийслэлийн төсөв, бусад эх үүсвэрээс санхүүжих зам барилгын ажлын худалдан авах ажиллагааг шуурхай	5 дугаар сар	Үйл ажиллагаа, төлөвлөлтийн хэлтэс	-

	зохион байгуулж, шалгарсан гүйцэтгэгчтэй яаралтай гэрээ байгуулах			
6	Газрын худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр /tender.gov.mn/ зохион байгуулах, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулах	Тогтмол	Үйл ажиллагаа, төлөвлөлтийн хэлтэс	-
7	Бараа худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үндэсний үйлдвэрлэлийн барааг импортоор ирж байгаа бараанаас тусад нь багцалж зохион байгуулах	Тогтмол	Үйл ажиллагаа, төлөвлөлтийн хэлтэс	-
8	Сангийн сайдын 2017 оны 348 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт хөтлөх аргачлал"-ыг хөтлөх	Тогтмол	Захиргаа, санхүүгийн хэлтэс	Нийт хэлтэс албадууд
9	2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлтийн гарсан зөрчил, дутагдлыг дахин гаргахгүй тал дээр анхаарч ажиллах, зөрчил дутагдлыг тухай бүр арилгаж, шийдвэрлэх	Тогтмол	Захиргаа, санхүүгийн хэлтэс	Нийт хэлтэс албадууд